

ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БЭХЖҮҮЛЭХ-2 ТӨСЛИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

1. Төслийн ерөнхий мэдээлэл:

а) Төслийн нэр:

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх”-2 төсөл

б) DIGNI дугаар: 10605

с) Төслийн хөгжлийн зорилго:

Зорилтот аймгуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх

д) Төслийн зорилт:

1. Зорилтот аймгуудын эрүүл мэндийн салбарын удирдлага, мэргэжилтнүүд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үр дүнтэйгээр хянах, бэхжүүлэх
2. Зорилтот аймгуудын хүн амд үйлчлүүлэгч төвтэй, чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх
3. Зорилтот аймгуудын хүн амын эрүүл мэндийн мэдлэг, хандлага сайжрах

2) 2015 оны төлөвлөгөөний дагуу төсөл ямар түвшинд, хэрхэн хэрэгжсэн бэ? Төслийн баримт бичиг, 2015 оны төлөвлөгөөтэй харьцуулахад төслийн үйл ажиллагаа, төсөлд ямар ямар өөрчлөлтүүд гарсан бэ?

Төслийн 2015 оны төлөвлөсөн ажлууд 100% сайн хэрэгжсэн. Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас 19 үйл ажиллагаа нислэгийн хуваарийн өөрчлөлт, сургагч багш нар болон орон нутгийн хамтрагчдын ажлын давхардал, ачаалал зэргээс шалтгаалан хугацаа хойшлогдон хэрэгжсэн. Төслийн баримт бичигт тусгасны дагуу сургалт, үйл ажиллагаа төлөвлөгдөн хэрэгжсэн ба АЭМГ болон АБСГ-ын мэргэжилтнүүдийн оролцоо өмнөх оноос нэмэгдэв.

Төслийн жилийн төлөвлөгөө болон бичиг баримттай харьцуулахад 2015 онд зорилтот аймгуудын болон ЭМЯ-ны хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах зарим үйл ажиллагаануудыг нэмэлтээр зохион байгуулсан байна.

- ЭМГ-ын зарим шинэ, ажлын туршлага багатай мэргэжилтнүүдэд бие даан хяналт үнэлгээ хийх ур чадвар хангалтгүй байсан. Иймээс энэ хэрэгцээнд үндэслэн тухайн онд нэмэлтээр ЭМГ-ын мэргэжилтнүүдэд оролцооны аргаар дотоод сургалт зохион байгуулж, хяналт үнэлгээний шалгах хуудсыг өөрийн аймгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дахин боловсруулан мөрддөг болсноор мэргэжилтнүүдийн ур чадвар жигд дээшлэн, хяналт үнэлгээний ажлын хүртээмж, үр нөлөө илүү сайжирч байна.
- ЭМСЯ-ны хүсэлтээр ЭМГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Р.Байгалмааг БӨ, ГА аймагт ажиллуулж, ЭМГ-ын мэргэжилтнүүдэд газар дээр нь арга зүйн зөвлөлгөө дэмжлэг үзүүллээ.
- АЭМГ-ын мэргэжилтнүүдийн баг Увс, Завхан, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын ЭМГ болон анхан шатны байгууллагуудын туршлагыг судалсан нь тэдэнд шинийг санаачлан бүтээлчээр ажиллах урам зориг өгч, олон туршлагуудыг нэвтрүүлсэн байна.
- Хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр ХӨЦМ-ийн шинэчилсэн хөтөлбөрийн сургалтууд зохион байгуулагдсанаар хүүхдийн зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлж, тусламж үйлчилгээ сайжирч 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл ГА аймагт 11,4 пормилль, Ховд аймагт 0,9 пормилль-оор буурсан, БӨ аймагт 4,9 пормилль-оор өссөн байна
- СӨЭМТ-ийн зарим мэргэжилтнүүд “Төсөл бичих арга зүй” сургалтад хамрагдан чадваржсанаар шаардлагатай санхүүжилт болон тоног төхөөрөмжийг төсөл бичих замаар олж санхүүгийн нөөц болон техник хэрэгслийн хангамжаа нэмэгдүүлсэн байна. Ялангуяа

хүүхдийн сувилал гаргах, олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгаа зэрэгт дутагдаж буй санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлж байна.

- Төслийн баримт бичигт тусгагдаагүй боловч чухал хэрэгцээтэй үйл ажиллагаа болох “Хүүхдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” бүсийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсны үр дүнд ЭМГ, БСГ-ын хамтын ажиллагаа сайжирч “Эрүүл мэндийг дэмжигч загвар сургууль”-иуд харилцан туршлагаа солилцсоноор үйл ажиллагаа нь жигдэрч, Ховд аймгийн 7-р сургууль БСШУЯ-ны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж үндэсний хэмжээний Загвар сургууль болоод байна.
- Баян-Өлгий аймгийн БСГ, ЭМГ-ын хамтын ажиллагаа сайжирч сургуулиудын захирлуудын холбоотой хамтран “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье” сэдэвт сургалтыг зохион байгуулснаар удирдлагуудын мэдлэг, хандлагад мэдэгдэм өөрчлөлт гарч эхэлж байна.
- Боловсролын яам, аймгуудын БСГ-ууд болон ХЭХ-2 төсөлтэй хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр хамтын ажиллагаа сайжирч ялангуяа аймгийн ЭМГ болон БСГ ууд 5-6 үйл ажиллагааг хамтран явуулсан нь хүүхдийн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдэхэд эерэг нөлөө үзүүлж байна.
- Боловсрол соёлын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсүүдтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа улам өргөжин зорилтот аймгуудын ЕБС-иуд төслийн боловсруулсан аргачлалын дагуу “Хүүхдэд ээлтэй орчин”- ы үнэлгээ болон дотуур байрын орчны үнэлгээг дотооддоо хийж хэвшиж байна.
- Зорилтот аймаг бүрт эрүүл мэндийг дэмжигч “Загвар сургууль” бий болсон, туршлагаа бусадтайгаа хуваалцсан.
- 2015 оны олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг нэгдсэн хэлбэрээр аймгуудад ижил байхаар төлөвлөж, өмнөх жилүүдэд хийсэн ажлын үр дүнг үнэлэх, аяныг уралдаан хэлбэрээр зарлаж, өөрсдөөр нь шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн ажил хийлгэж, дүгнэсэн нь бага санхүүжилтээр олныг хамарсан, бүтээлч ажил боллоо. ¹
- АХЭМ, хүүхдийн шүдийг хамгаалах, эрүүлжүүлэхэд ихээхэн анхаарч, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь нэмэгдэж, хүүхдийн шүдний өвчлөл төсөл эхэлсэн 2013 онтой харьцуулахад 20 хүртэл хувь буурсан байна.

3) Жилийн туршид хүрсэн үр дүн юу байв?

Зорилт - 1

Тус зорилтын хүрээнд ЭМГ-ын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, хяналт үнэлгээний ажлын хэсгийн уулзалт, өөрийн аймгийн загвар ЭМТ болон бусад аймгийн ЭМГ-ын сайн туршлагаас суралцах аялал гэсэн 4 чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулж дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- ЭМГ-ын мэргэжилтнүүд 100% 1-3 удаа сургалтанд хамрагдаж, сургалтын дараах сорилын үр дүн дунджаар /БӨ-27,6%, ГА-31%, Ховд -51%/ 36,6²⁰%-иар нэмэгдсэн нь 2015 онд хүрэх шалгуур үзүүлэлтийг³ хангасан байна.
- Аймаг бүр өөрийн онцлогт тохируулсан хяналт үнэлгээ хийхэд баримтлах зарчим, шалгах хуудсыг шинээр боловсруулан, мөрдөж эхлээд байна.
- СӨЭМТ-үүдэд тогтмол хяналт үнэлгээ хийдэг болсон ба хяналт үнэлгээнд /БӨ-1.164.000, ГА-2,2 сая, Ховд 388.000 төгрөг/ нийт 3.752.000 төгрөг зарцуулсан байна. Энэ нь өмнөх оныхоос /БӨ-2722000, ГА-2600000 сая, Ховд 280.000 нийт 5.602.000 төгрөг/ буурсан ч эдийн засгийн хямралтай, төрийн байгууллагуудын хяналт үнэлгээ хийх зардлыг танасан энэ үед чухал үзүүлэлт гэж үзэж байна.

¹ Аймгуудын жилийн эцсийн тайлангуудаас

² Training check list 2015

³ 2015 оны шалгуур үзүүлэлт 1.2b: сургалтын дараах тестийн үр дүн өмнөх тесттэй харьцуулахад 30-аад доошгүй хувиар нэмэгдсэн байна.

- Аймгийн ЭМГ болон БСГ хамтран олон ажлуудыг уламжлал болгон зохион байгуулснаар цэцэрлэг, ЕБС-иуд хүүхдийн эрүүл мэндэд анхаардаг болсон ба /БӨ-9, ГА-9, Ховд-11/ нийт 29 үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан байна⁴. Төслөөс зохион байгуулж байгаа бүхий л үйл ажиллагаанд эдгээр байгууллагын мэргэжилтнүүд санаачилгатай тогтмол оролцож, хариуцан зохион байгуулдаг болсон.
- АЭМГ-аас анхан шатанд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулахад зориулан 2015 онд /БӨ-2722000, ГА-2300000/ нийт 5.022.000 төгрөг зарцуулсан, өөрийн орон нутагт тохирсон хяналт үнэлгээний аргачлалыг боловсруулан ашигладаг болсон, АЭМГ-ын дэмжлэгт үйл ажиллагаанд СӨЭМТ-үүдийн эмч, мэргэжилтнүүдийн сэтгэл ханамж /БӨ-78%, ГА-86%, Ховд-70%/ аймгуудийн дунджаар 78% /2014 онд 69% байсан/ болж 9%-иар дээшилсэн байна.⁵
- АЭМГ-ын 36 мэргэжилтнүүд багаараа Увс, Завхан, Булган, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай аймгуудийн ЭМГ болон анхан шатны байгууллагуудын туршлагыг судалсан нь тэдэнд шинийг санаачлан бүтээлчээр ажиллах урам зориг өгч, олон туршлагуудыг нэвтрүүлсэн байна.

Зорилт – 2

Төслийн баримт бичиг, орон нутгийн хэрэгцээг үндэслэн 14 сэдвийн хүрээнд СӨЭМТ-ийн их эмч, багийн эмч, НЭМ, сувилагч, дархлаажуулалтын сувилагч нарт зориулсан ажлын байрны болон танхимын сургалт, туршлага судлах уулзалтуудыг ЭМШУҮИС-ийн МДИ, ЭМХҮТ-өөр батлуулсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, 1124 хүнийг хамруулан багц цаг олгосон байна. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд:

- СЭМТ, НЭ-ийн хамтын үйл ажиллагаа сайжирсан.
- ГА аймгийн ӨЭМТ-үүд нийт 2015 онд 1531 хүнд түргэлчилсэн оношлуураар шинжилгээ хийж эерэг гарсан 162 хүнийг дараагийн шатлалд илгээж, баталгаажуулсан ба ӨЭМТ-ээр үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.
- Ховд аймгийн СЭМТ-ийн дарга нар сувилахуйн үйл ажиллагааны талаар мэдлэгтэй болсноор үнэлж хяналт хийдэг болсон.
- Ажлын байрны сургалт /зөвлөн туслах баг/-ыг 10 суманд хийснээр тухайн сумдын бичиг баримт, эх хүүхдийн хяналт, халдвар хамгаалал болон бусад үйлчилгээний чанар сайжирч, эмч мэргэжилтнүүд нь чадваржсан.
- Аймаг бүрт нэг удаагийн бүсийн зөвлөлдөх уулзалтыг ЭМЯ, БСШУЯ, аймгийн ЗДТГ, ЭМГ-уудтай хамтран зохион байгууллаа.⁶
- СӨЭМТ-үүд хүүхдэд эмнэлгийн яаралтай тусламжийг эрэмбэлэн ангилалтын дагуу цаг алдалгүй зөв үзүүлж чаддаг болсон.
- Загвар ЭМТ болон сургууль, цэцэрлэгийн бүлгүүдийн төсөлд нийт 8.418.900 дэмжлэг үзүүлсэн нь тэдэнд урам өгч, сэргээж, бусдад туршлагаа түгээн дэлгэрүүлэх сонирхлыг нь төрүүлж чадлаа.
- СӨЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар дээшилснээр анхан шатны тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж, сум, өрхийн эмч нараар оношлогдсон хүмүүсийн тоо /БӨ-18385, ГА-9484, Ховд-2240/ бүх аймгуудад 27869 болсон байна.⁷

Зорилт -3

2015 онд олон нийтийн сургалт, сурталчилгаа, уулзалт, ухуулга нөлөөллийн ажлыг хүүхдийн эрүүл мэнд, орчны эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр зохион байгуулав. Тухайн зорилтын хүрээнд аймаг бүрт нийт 12 багц үйл ажиллагааг төлөвлөсөн бөгөөд биелэлт 91,6-100 хувьтай байна.

4 2015 оны шалгуур үзүүлэлт 1.4а: Аймгийн ЭМГ, БСГ хамтарсан 5-6 үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

5 СӨЭМТ-д хамтарсан хяналт үнэлгээ хийх үед авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнгээр тодорхойлсон.

6 2015 оны шалгуур үзүүлэлт 2.4а: ЭМЯ-ны дэмжлэгтэйгээр АЭМГ-ууд 3 форумыг зохион байгуулсан байна.

7 АЭМГ-ын статистик үзүүлэлтээс авсан

Онцлог талууд:

- БСШУЯ төслийн хүрээнд баруун бүс нутгийн хүүхдийн эрүүл мэндийн төлөө хийж буй үйл ажиллагаанд илүүтэй анхаарал хандуулдаг боллоо. БСШУЯ-ны удирдах зөвлөлийн уулзалтанд уригдан оролцож, төслөөс хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны талаар танилцууллаа. Аймаг сумын ЗДТГ-ууд “Орчны эрүүл мэндийн” чиглэлээр өөр өөрийн онцлогт нийцсэн захирамж, тушаал шийдвэр гарган тусгайлан хөрөнгө гаргаж, болзолт уралдаан, ухуулга, нөлөөлөл, сургалт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, дүгнэн ажиллаж байна.
- Осол гэмтлээс сэргийлэх аяны хүрээнд “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье” сэдэвт цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нарын уулзалт, сургалтыг зохион байгуулсан нь ЭМГ, БСГ-ын хамтын ажиллагааг сайжруулах, Боловсролын байгууллагуудын хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн үйл ажиллагааны хүртээмж, үр дүнг сайжруулах, харилцан сайн туршлагаа хуваалцахаас гадна эрүүл зан үйлийг хүүхэд наснаас төлөвшүүлэх нь чухал зүйл гэдгийг ойлгуулснаараа нэн хэрэгцээтэй байсан нь оролцогчдын сэтгэл ханамжаас харагдаж байлаа.⁸
- Зорилтот аймгуудын сурагчдын дунд Эрүүл мэндийн хичээлийн олимпиадыг анх 3 жилийн өмнөөс санаачлан аймгуудын БСГ-уудтай хамтран зохион байгуулсан туршлагыг БСШУЯ үнэлж, биднийг дэмжин сайдын тушаал гарган улс орон даяар анх удаагаа мөн онд зохион байгуулж, шилдэг анги, багш сурагчдыг шалгаруулсан байна. Энэ онд Говь-Алтай, Ховд аймгийн 47 сургуулийн 8,9,12 дугаар ангийн 92 бүлгийн 2499 сурагч хамрагдлаа. Сорилын дүнгээс үзэхэд АХЭМ, гар угаахын ач холбогдол, эмийн тухай, халдварт өвчний талаар мэдээллүүд хамгийн өндөр хувьтай байгаа нь төслийн үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа нэгжүүдэд хүрч, оролцогчдын мэдлэг дээшилж, сургалтын дараа үр дүнтэй ажлууд санаачлан зохион байгуулж, хэвшсэнийг илэрхийлж байна.

“Хүүхдийн эрүүл мэнд аян”-ы хүрээнд: АХЭМ, осол гэмтэл, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр хүүхдэд чиглэсэн ажлуудыг ЭМГ, БСГ, сургууль, цэцэрлэгүүд, ӨЭМТ, төрийн болон ТББ, холбоодуудтай хамтран аймгийн хэмжээнд 3 сарын аян зарлаж, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн, төсөл бичүүлж, үйл ажиллагааг санхүүжүүлэхийн зэрэгцээ, судалгаа, дүгнэлт хийхэд анхаарч ажилласан. Мөн хүүхдийн сувилал ажиллуулахад Ховд аймгийн төвийн бүх ӨЭМТ-ийг хамруулан тус бүр 250.000 төгрөг нийт 1.250.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн 6 сараас 3 настай 150 хүүхэд, Говь-Алтай аймгийн 6 суманд тус бүр 200.000 төгрөг нийт 1.200.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн 158 хүүхдийг асран хамгаалагчийн хамт хамруулан хүүхдийн нэмэлт хоол тэжээл хэрхэн бэлтгэх, хүүхдийн асаргаа сувилгаа хийх, суурь өвчнөөс хэрхэн сэргийлэх арга зүйд сургаж, жингийн хоцрогдлыг 50-60 хувь бууруулж ажиллалаа.

Тус аяны хүрээнд АХЭМ, антибиотекийн хэрэглээнд үнэлгээ хийх, Ховд аймгийн Зэрэг суманд сумын ЭМТ-ийн хүсэлтийн дагуу сайн санааны туслагч бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. Говь-Алтай аймгийн хэмжээнд шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт 21095 иргэн, эмчилгээнд 17000 гаруй хүн, хөдөөгийн 18 сумын 9183 хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан нь хамрагдвал зохих нийт хүүхдийн 65 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд 5, 6 настай хүүхдүүдийн дунд шүдний өвчлөлийн эрчим 4.5, 12 настай хүүхдүүдийн шүдний өвчлөлийн эрчим 2,8 болж, урьд оны мөн үеэс 0,6-аар буурсан үр дүнтэй байгаа нь хүүхдийн АХЭМ-ийн асуудалд эцэг эх, багш, удирдлагууд анхаарлаа хандуулж, хүүхдийн шүдийг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлууд сум орон нутагтаа зохион байгуулж хэвшсэнийг илэрхийлэл юм.⁹

⁸ Зорилтот аймгуудын “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье” сэдэвт сургалтын тайлангуудаас

⁹ Говь-Алтай аймгийн жилийн эцсийн тайлангаас

Орчны эрүүл мэнд аяны хүрээнд: Төслийн аймгууд тус аяны хүрээнд өмнөх жилүүдэд зарлаж байсан уралдаант ажлуудыг санаачлан зохин байгууллаа. Тухайлбал: Ховд аймаг “Эрүүл гудамж Миний хашаанаас-2” аяныг аймгийн ЗД-ын захирамжаар ажлын хэсэг байгуулан аймгийн төвийн багуудын дунд зарлаж, ГА аймгийн хувьд “Цэмцгэр-Алтайн-Цэвэрхэн гудамж” 3 сарын аяныг сумууд өөрсдийн хэмжээнд зохион байгуулж, Дэлгэр, Төгрөг, Хөхморьт, Жаргалан сумын байгууллагууд 16 стандартын шаардлага хангасан бие засах газар шинээр байгуулсан байна. Баян-Өлгий аймгийн төвийн “Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж” бүхий 13 баг, Бугат сумын иргэдэд ухуулга нөлөөллийн ажлыг хийж, гарын авлага материал тарааснаар иргэдийн оролцоо нэмэгдэж, өөрсдөө хашаа, бие засах газар, бохир усны цооног, хаалгаа шинэчилсэн, сайжруулсан зэрэг үр дүн гарсан байна. Мөн ДХҮ- ний үеэр фокус бүлгийн ярилцлагыг тус загвар гудамжны иргэдтэй хийсэн бөгөөд ярилцлагын явцад иргэдийн хувьд маш их зүйлийг хийсэн, бодитой өөрчлөлтүүд гарсан орчин нөхцөл сайжирсан, эрүүл дадал зан үйлийг төлөвшүүлж чадсан бөгөөд цаашдаа хийх эрмэлзэл дүүрэн байгаагаа илэрхийлж байлаа. Мөн тэд өөрсдийн энэ туршлага амжилтаа бусдадаа түгээх, аймгаараа өөрчлөгдөхийг дэмжихийг хүсэж байв. Гэвч аймаг бүхэнд аяны үйл ажиллагаа харилцан адилгүй байна. Ховд аймгийн хувьд аймгийн ЗД-ын дэмжлэгийг сайн авч байгаа тул өмнө бий болсон үр дүнгээ хадгалахын зэрэгцээ, цаашид загвар гудамжны тоо өссөөр байгаа бол нөгөө 2 аймгууд нутгийн удирдлагын байгууллагын дэмжлэг оролцоог төдийлөн сайн авч чадахгүй байгаа нь аймгуудын хувьд төдийлөн үр дүнгээ ахиулж чадахгүй хэвээр байна.¹⁰

Эрүүл мэндийг дэмжигч загвар сургуулиуд аймаг бүрт бий болж, үйл ажиллагаа нь идэвхжсээр байна. Ховд аймгийн 7 дугаар сургуульд маш олон өөрчлөлт гарч Улсын хэмжээнд загвар сургуулийн болзлыг хангасан үр дүнд хүрлээ. БӨ-аймгийн 2 дугаар бага сургууль “Сургуулийн орчноос хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх” хуудсаар өөрсдийгөө үнэлж, хэвшсэн туршлагатай болсон төдийгүй дүнгээ нийт сургуулийн захирлуудын уулзалтанд танилцуулж, тухайн үнэлгээний үр нөлөө болон хэрэглэхэд хялбар, энгийн ойлгомжтой гэдгийг бусдадаа сурталчиллаа. Энэ нь тус үнэлгээний аргачлалыг жигд хэрэглэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болов. Мөн 1 дүгээр бага сургууль 2 бүлэгтээ шүд угаах аргачлалыг туршиж байгаа нь тус аймгийн бусад сургуульд туршлага болж чадлаа. Өмнөх жилүүдэд Баян-Өлгий аймгийн боловсролын салбарын удирдлагуудын хандлагыг өөрчлөх нь төслийн хувьд анхаарал татсан асуудал байсаар ирсэн бөгөөд 2016 онд эргэлт гарна гэсэн итгэл төрж байна.¹¹

- АХЭМ- ийн чиглэлээр төсөл эхэлснээс хойш олон талт ажлуудыг зохион байгуулж ирсэний дүнд хүүхдийн шүдний өвчлөл төсөл эхэлсэнтэй харьцуулахад зорилтот аймгуудад дунджаар 20 хүртэл хувь буурсан байна.
- Орон нутгийн эрүүл мэнд боловсролын байгууллагуудын санал санаачилгыг дэмжин жижиг төслүүдийг шалгаруулан хүүхдийн сувилал, олон нийтийн сургалт, уралдаан тэмцээн зэрэг үйл ажиллагаа зохион байгуулахын зэрэгцээ СӨЭМТ-үүд өөрсдөө санаачлан төслийн санхүүжилтээр АХЭМ, осол гэмлтээс сэргийлэх талаар 5.124.560 төгрөг зарцуулж, 1703 хүн хамруулсан сургалт зохион байгуулсан байна.
- Ховд аймагт “Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж”-ны ажлуудад төслийн оролцоо багасаж, аймгийн ЗДТГ аль хэдийн өөрийн арга барилаар үр дүнтэйгээр удирдан зохион байгуулж, түгэн дэлгэрч байна.
- Хүүхэд болон Орчны эрүүл мэндийн аяны хүрээнд ДЗМОУБ, сумын эмч нарын холбоо, насан туршийн боловсролын төвүүд, сургуулийн захирлуудын холбоо, эмэгтэйчүүдийн

¹⁰ Аймгуудын жилийн эцсийн болон үйл ажиллагааны тайлангуудаас

¹¹ “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх” сэдэвт сургуулийн захирлуудын уулзалт, сургалтын тайлангаас

холбоо, эрүүл мэндийн клубууд зэрэг ТББ-д үр дүнтэй хамтран ажиллаж хэвшсэн, тогтвортой байдал бий болсон байна.

- 2015 оны олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг нэгдсэн хэлбэрээр аймгуудад ижил байхаар төлөвлөж, өмнөх жилүүдэд хийсэн ажлын үр дүнг үнэлэх, аяныг уралдаан хэлбэрээр зарлаж, өөрсдөөр нь шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн ажил хийлгэж, дүгнэсэн нь бага санхүүжилтээр олныг хамарсан, бүтээлч ажил боллоо.¹²
- Эрүүл шүдтэй анги шалгаруулах болзолт уралдаан зарласнаар сургууль, цэцэрлэг, шүд эрүүлжүүлэх ажлууд эрчимжиж, уралдаанд 3 аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 11 сургууль, 35 цэцэрлэгээс, сургуулиуд бүрэн оролцож, 346 хүүхдийг хамруулан 60,7 хувь нь шүдээ эрүүлжүүлсэн байна. Тус уралдаанд хамрагдвал зохих 33 цэцэрлэгээс 22 цэцэрлэг оролцож, 2857 хүүхдийг хамруулж 61,6 хувь буюу 1760 хүүхдийн шүдийг эрүүлжүүлээд байна.¹³ Шагналын санд нийт 3 сая төгрөг зарцуулсан.

4) Төслийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд нөлөөлсөн ямар нэгэн онцгой нөхцөл (эерэг ба сөрөг байдлаар) байсан уу? (тогтвортой байдал, орон нутгийн өөриймсөг байдал, улс төр ба хууль эрхийн нөхцөл байдал гэх мэт)

А)Дотоод хүчин зүйл:

1. Эерэг:

- Төслийн ажилтнуудын чадвар, туршлага нэмэгдсэн.
- Төслийн жилийн төлөвлөгөө, төсвийн төлөвлөлт орон нутгийн онцлог, хамтрагчдын ажлын ачаалал зэргийг харгалзан хэрэгжихүйц, бодитой, төслийн шалгуур үзүүлэлтэд чиглэж нарийвчлан хийгдэж чадсан.
- 2015 оны төлөвлөлтийг аймаг бүхэнд ижил байхаар, ялангуяа олон нийтийн арга хэмжээний ерөнхий чиглэлийг гаргаж төлөвлөсөн нь үр дүнгээ үнэлэх, хамтрагчдын оролцоог хангахад чухал байлаа.
- Санхүүгийн тогтвортой байдал
- Байгууллагын удирдлагын дэмжлэг хамтын ажиллагаа сайн байв.

2. Сөрөг:

-Төсөл хэрэгжсэн хугацаа, төслийн ажилтнуудын туршлага, ур чадвар, санаачилга, зэргээс олон нийтийн дунд зохион байгуулсан ажлын үр дүн өөрчлөлт харилцан адилгүй төдийгүй, зарим ажлууд тодорхой хязгаарлагдмал байдлаар зохион байгуулагдсанаас зарим газруудад олон нийт төслийн талаар мэдээлэл дутмаг байсан нь дунд хугацааны үнэлгээгээр харагдаж байсан. Мөн олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаануудын үр дүн болон эрүүл зөв дадал хандлагын өөрчлөлтийг үнэлэх боломж, мэдлэг, туршлага, ур чадвар төслийн багийнхан төдийгүй үндэсний хэмжээнд дутагдалтай байгаагаас өөрчлөлтийг тодорхой илтгэж чадахгүй байна.

В)Гадаад хүчин зүйл:

1. Эерэг:

- Эрүүл мэнд болон боловсролын яам бусад үндэсний түвшний хамтрагчдын дэмжлэг, хамтын ажиллагаа сайн, ямар нэгэн бэршээл учирч байсангүй.
- Орон нутгийн хамтрагчдын хамтын ажиллагаа, төсөлд хандах өөриймсөг эерэг хандлага улам бэхэжсэн.
- Орон нутгийн боловсролын салбарын удирдлагуудын хүүхдийн эрүүл мэндийн төлөө хандах хандлага сайжирч, эерэг өөрчлөлтүүд гарсан.

2. Сөрөг:

¹² Аймгуудын жилийн эцсийн тайлангуудаас

¹³ Эрүүл шүдтэй анги шалгаруулах уралдаан тэмцээний тайлангуудаас

- Эдийн засгийн хямрал бүх шатанд бүх салбарт бий болсон /Үнэ ханш өсөн нэмэгдсэн, хамтрагчдын оролцооны зардал буурсан/
- Орон нутгийн гол хамтрагчдын удирдлагыг улс төрийн шалтгаанаар олон дахин өөрчилсөн.
- Хамтрагчдад төлөвлөөгөөгүй гэнэтийн үйл ажиллагаа гарч ирсэнтэй холбоотой давхардал гарснаас зарим үйл ажиллагааг хойшлогдож байсан.
- Зарим аймагт хамтрагчдын оролцоо харилцан адилгүй байдаг нь үйл ажиллагааг явуулах боломжгүй байдал үүсгэж байлаа. Тухайлбал: БӨ аймагт Эрүүл мэндийн олимпиадыг БСГ-ын дэмжлэгийг авч чадаагүй тул явуулах боломжгүй байлаа.

5) Төслийн гэрээт хугацаа дууссаны дараа тогтвортой байдлыг хангах болон төсөл дуусах шатанд бэлдэхэд төслийн зүгээс ямар арга хэмжээ авсан бэ?

а. Төслийн үйл ажиллагаа хэрэгжиж дууссаны дараа ямар үйл ажиллагааг хэн хариуцаж цаашид үргэлжлүүлэх вэ ?

Үйл ажиллагаа	Хэн хариуцах
ЭМГ-ын мэргэжилтнүүд болон анхан шатанд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд нь тасралтгүй сургалт, шавилан сургалт явуулах, чадавхижуулах	ЭМЯ, ЭМХҮТ, Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, БОЭТ
Загвар эрүүл мэндийн төв, Загвар сургууль Загвар цэцэрлэгийн туршлага түгээх	Аймгийн ЭМГ, БСГ, ЭМТ, Сургууль, цэцэрлэгийн дарга нар
Бүсийн зөвлөлдөх уулзалтууд, Туршлага хуваалцах	Аймгийн ЗДТГ-ын НХХ, Удирдах зөвлөлийн гишүүд, ЭМГ, БСГ
Хяналт үнэлгээг тасралтгүй, удирдамжийн дагуу, зөвлөн туслах зарчмаар гүйцэтгэх	ЭМГ, БСГ-ын мэргэжилтнүүд болон эрүүл мэнд боловсролын байгууллагын дарга нар
Зөвлөн туслах багийг газар дээр нь ажиллуулах	ЭМГ, Сумдын ЭМТ-ийн дарга нар
СӨЭМТ-дийн чанарын багийн үйл ажиллагаа	СӨЭМТ-ийн мэргэжилтнүүд чадваржсан, ЭМГ-аас хяналт сайжирсан.
Эмнэлгийн мэргэжилтний зайн сургалтыг тасралтгүй зохион байгуулах	ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтнүүд, сум өрхийн ЭМТ-ийн эрхлэгч нар
Эрүүл мэндийн дэмжигч Загвар гудамж	Аймаг, Сумын ЗДТГ
Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	ЭМСЯ, БСШУЯ, Аймаг сумдын ИТХ, ЗДТГ, ЭМГ, БСГ
Олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгаа, кампанит ажлууд	ЭМГ-ын мэргэжилтнүүд, СӨЭМТ-дийн НЭМ-ийн ажилтнууд /мэдлэг ур чадвар хангалттай эзэмшсэн/, Орон нутгийн ТҮ, сонин, Радио, Сумдын ЗДТГ/ санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болсон/

в. Төслийн хөгжлийн зорилго, урт хугацааны үр дүнг бэхжүүлэхийн тулд төсөл хэрхэн ажиллаж байна вэ? (удирлага, мэдлэг/ур чадвар, санхүү талаас)

- ЭМСЯ, БСШУЯ зэрэг үндэсний хэмжээний байгууллагуудад үйл ажиллагаагаа сурталчилан таниулах, ухуулга нөлөөллийн үйл ажиллагаанууд зохион байгуулдаг.
- Зорилтот аймгийн удирдлагууд, хамтрагч нарт төслийн зорилго, чиглэл, үйл ажиллагааг тогтмол танилцуулж, ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг тасралтгүй хийдэг.
- Төслийн төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн болон салбарын яамдын холбогдох мэргэжилтний саналыг авдаг, танилцуулж хамтран ажилладаг.
- Орон нутгийн удирдах зөвлөлийн үүрэг оролцоо, дэмжлэгийг байнга авдаг.

- Зорилтот аймгуудын сайн туршлагаудыг хуваалцах боломжоор хангаж, санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлдэг.
- Төслийн зорилтот бүлэгт чиглэсэн орон нутгийн санал санаачилгыг дэмжиж, хамтран ажилладаг.
- Хамтрагчдын жилийн зөвлөлдөх уулзалт, Дунд хугацааны тайлангийн хурал зэрэг хурал уулзалтад орон нутгийн хамтрагчдыг оролцуулж, тэдний санал, дүгнэлтийг төсөл хэрэгжүүлэхэд анхаарч мэдээллийг нээлттэй харилцан солилцдог.

б) Төслийн үр дүнг үндэсний бодлого, төлөвлөгөө, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж холбохын тулд юу хийсэн бэ?

- ✓ Үндэсний хэмжээний бодлого хөтөлбөрийг судлан, жил жилийн төлөвлөгөөг боловсруулах үе шат бүрт анхаарч тусган хэрэгжүүлдэг,
- ✓ Зорилтот аймгуудын эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг сар, жилээр харьцуулан судалж үр дүн хангалтгүй байгаа үзүүлэлтүүдийг сайжруулахад дэмжиж хамтран ажилладаг.
- ✓ ДЭМБ болон ЭМСЯ, БСШУЯ наас зохион байгуулсан зарим уулзалт хурал семинарт төслийн удирдагч болон ажилтнуудаас оролцдог.
- ✓ Бүсийн хэмжээний зөвлөлдөх уулзалтуудад ЭМСЯ, БСШУЯ ны холбогдох мэргэжилтнүүдийг тогтмол оролцуулж, тухайн чиглэлээр үндэсний хэмжээнд баримталж буй бодлого стратеги, хийж буй ажлууд, өөрчлөлтийн талаар мэдээлэл хийлгэж хэвшсэн.
- ✓ Төслийн бүхий л үйл ажиллагааг үндэсний бодлого хөтөлбөр болон орон нутгийн хэрэгцээтэй уялдуулж хамтран хэрэгжүүлж байна. Тухайлбал дараах бодлого стратегиудын хүрээнд төслийг уялдуулан хэрэгжүүлж байна.
 - ДЭМБ-ын орон нутагт эрүүл мэндийн системийг бэхжүүлэх стратеги
 - ЭМЯ- наас 2015 оныг Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих жил” болгон зарласан.
 - Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр
 - Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үндэсний стратеги
- ЭМЯ ны Сум, ӨЭМТ ийн шинэчлэлийг стратеги, ЭМ байгуулагуудын хяналт үнэлгээний удирдамж
- ХӨЦМ- ийн шинэчилсэн хөтөлбөр
- Сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх стратеги
- СӨЭМТ-ийн оношилгооны чадамжийг сайжруулах зорилгоор лаборант нарын шавилан сургалт, НЭМ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон нийтэд зориулсан жижиг төслийн уралдаан, Сувилахуйн загвар төвийн үйл ажиллагааг үнэлэх хуудас, сувилахуйн сургалт зэргийг зохион байгуулж, СӨЭМТ-үүдэд эрэгтэйчүүдэд зориулсан НЭМ-ийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар ухуулга нөлөөллийн ажил хийж, хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтэндээ оруулсан.
- Сургууль цэцэрлэгийн орчны стандартыг хангах тухай Боловсролын сайдын тушаал/ Шүд гар угаах дадал эзэмшүүлэх, бие засах орчны стандартыг хангах зэрэг заалтууд байгаа/
- БСШУЯ ны гэр бүлд суурилсан хүүхэд хөгжлийн стратеги
- Хүүхдийн эрүүл мэндэд эцэг эхийг оролцоог хангах хөтөлбөр
- Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр
- Өсвөр үеийн хүүхдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд охидын жирэмслэлт болон өсөлт хоцрогдол их байгаад анхаарч сургуулийн эмч, эрүүл мэндийн багш, нийгмийн ажилтнуудад “Өсвөр үеийнхний эрүүл мэндийн чиг баримжаа олгох” сургагч багшийн сургалтыг зохион байгуулснаар хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад анхаарах, эрүүл мэндийн хичээлийн агуулгыг бүх багш нар олгох БСШУЯ-ны тушаал шийдвэрт нийцсэн арга хэмжээ болсон.
- Сургууль, цэцэрлэгийн орчны стандартын шаардлагыг хангах тухай 3 яамны хамтарсан тушаалын 5 дугаар зүйл, хүүхдийн гар, шүд угаах зөв дадлыг бий болгох, сургуулийн

орчинд эрүүл ахуйн шаардлага хангасан бие засах газар, бохир усны цооног бий болгох ажлуудтай төслийн үндсэн үйл ажиллагаа уялдаж байна.

- Эрүүл мэндийг дэмжигч загвар сургууль бий болгох төслөөс гаргасан шалгуур үзүүлэлтийг илүү боловсронгуй болгож, БСШУЯ-наас улсын хэмжээнд авч үзэн уралдаан зарлаж, дүгнэсэн.
- Эрүүл мэндийн олимпиадыг уламжлал болгон ЭМГ, БСГ-тай төслийн аймгууд зохион байгуулж хэвшсэн ба энэ оноос БСШУЯны сайдын тушаалаар улсын хэмжээнд явагдсан байна.

7) Хөгжлийн явц процест иргэний нийгмийн үүргийг бэхжүүлэхийн тулд юу хийсэн вэ?

a. Хамтрагч байгууллагуудын чадавх хэрхэн бэхжсэн бэ?

- Асуудлыг тодорхойлох болон хэрэгжүүлж буй үйл ажиллагаандаа олон нийтийг татан оролцуулах
- БСГ, ЭМГ-ийн мэргэжилтнүүд багаар хамтран ажиллах
- Дотоод болон хөндлөнгийн хяналт үнэлгээг тогтмол шинэлэг арга хэлбэрээр тасралтгүй зохион байгуулах, ЭМГ-ын мэргэжилтнүүд хяналт үнэлгээний удирдамж, шалгах хуудас боловсруулах, хяналт үнэлгээ хийх ур чадварт суралцсан
- Харилцан мэдээллээ нээлтэй солилцох
- Статистик мэдээ мэдээллийг удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах
- Чанарын үнэлгээг хийхэд түүвэр аргаар судалгаа, дүгнэлт хийх
- Тодорхой асуудал бүр дээр багаараа нээлтэй хэлэлцүүлэг хийх
- ЭМГ, БСГ-ын мэргэжилтнүүд бие биенийхээ ажлыг орон гүйцэтгэх
- СЭМТ-үүд бүсчилсэн сургалт, ажил мэргэжлийн уралдаан, туршлага судлах уулзалт зэргийг ЭМГ-ын дэмжлэгтэйгээр зохион байгуулах
- СӨЭМТ-үүд олон нийтэд зориулсан НЭМ-ийн үйл ажиллагааг олон хэлбэрээр бие даан зардлаа гарган зохион байгуулах
- АЗДТГ-аас эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд санхүүгийн болон удирдлагын дэмжлэг үзүүлдэг болсон
- БСГ-аас эрүүл мэндийг дэмжигч сургуулиудыг бий болгох арга зүйг эзэмшсэн. Аймаг бүрт 1-2 сургууль ЭМД сургууль болохоор ажиллаж байна.
- ЭМГ, БСГ, СӨЭМТ нь жижиг төсөл бичиж, хүүхдийн сувилал ажиллуулах, олон нийтийн сургалт зохион байгуулах эмийн зохистой хэрэглээ, осол гэмтэлээс сэргийлэх ухуулга нөлөөллийн ажлууд тогтолжиж байна.
- Эрүүл мэндийн кабинет шалгаруулах уралдаан зарласнаар шинээр кабинет байгуулах болон үйл ажиллагааг нь сэргээснээр эрүүл мэндийн хичээлийн үр дүн сайжирч, багш, эцэг эхчүүд хүүхдийн эрүүл мэндэд анхаарал хандуулах хандлага дээшилж байна.
- Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамжны үйл ажиллагааг зохион байгуулснаар багийн засаг дарга нар багийнхаа иргэдтэй хамтран ажиллах, эрүүл таатай орчин, бүрдүүлэхэд чухал болсон. Мөн орон нутгийн оролцоо, санаачилга нэмэгдэж байна. ¹⁴

b. Тогтвортой өөрчлөлтийг бий болгох иргэний нийгмийн байгууллагуудын чадавх хэрхэн сайжирсан бэ?

- Аймгуудын хэвлэл мэдээллийн ажилтны бүсийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, гэдхарицан туршлагаа хуваалцав.
- Үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн “Оюуны дархлаа” ТББ тай гэрээ байгуулан төслийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд таниулах, сурталчлах, орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сургаж чадваржуулах, харилцан мэдээлэл солилцоход мэргэжлийн дэмжлэг авч ажиллаж байна.

¹⁴ Дунд хугацааны үнэлгээний явцад Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамжны иргэдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл

- Аймгуудын Эмэгтэйчүүдийн зөвлөл ТББ, Залуучуудын холбоо, Ахмадын зөвлөл, сургуулийн захирлуудын холбоо, сумын эмч нарын холбоо зэрэг ТББ- дтай хамтран ажиллаж тэд өөрсдийн гишүүдэд эрүүл мэндийн мэдээлэл сургалт явуулах мэдлэг арга зүйг эзэмшсэн.
- Эрүүл мэндийг дэмжигч клубын хүүхдүүдийн дунд жижиг төсөл бичих уралдаан зарлан санхүүжүүлснээр тэдний чадвар, идэвх санаачилга, үе тэнгийнхэндээ нөлөөлөх нөлөөлөл нэмэгдсэн байна.

с. Шинээр бүлэг, сүлжээ бий болсон уу?

- Аймаг бүрт Эрүүл мэндийн дэмжигч загвар гудамжууд бий болж гудамж хорооллоороо иргэд нэгдэн гадаад орчноо тохижуулах, хаягжуулах, бие засах газар, бохир усны цооногийг стандартын шаардлагад нийцүүлж сайжруулах, шинээр байгуулах, хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх, хяналтад хамруулах, халдварт өвчин, , осол гэмтлээс сэргийлэх, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зэрэг эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааг хийдэг болсон.
- Ховд аймгийн сургуулийн эмч, НА-ууд “Өсвөр үеийн эрүүл мэнд” сургагч багшийн сургалтанд хамрагдаж байх үедээ сайн туршлагаадаа солилцох зорилгоор Facebook group шинээр нээн ажиллуулсан байна.

8) Хөгжлийн явц, процест эмэгтэйчүүд ба жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэхийн тулд юу хийсэн вэ? Тухайлбал:

a. Эмэгтэйчүүдийн оролцоог орон нутагт, хамтрагч байгууллагууд, төслийн шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэхийн тулд юу хийсэн бэ?

- Төслийн сургалт, үйл ажиллагаанд хамрагдагсдын 71 /13848/ хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.
- Орон нутгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудтай хамтран эрүүл мэндийн сургалт сурталчилгааг хийж байна.
- Төслийн удирдах зөвлөлийн гишүүдийн 28 хувь нь, хамтрагч СӨЭМТ болон цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтны 79 хувь нь эмэгтэйчүүд байна.
- ЭМ болон боловсролын яамнаас өнгөрсөн онд хамтарч ажилласан 11 мэргэжилтний 82 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.

b. Төслийн зүгээс хүний эрх, ялгаварлан гадуурхах байдлын эсрэг юу хийсэн бэ?

- Төслийн жилийн зөвлөлдөх уулзалтад үндэсний түвшний болон орон нутгийн хамтрагчдыг оролцуулж, тэдэнд хүний эрх, ялгаварлан гадуурхах байдал хүний эрхийн конвенцийн талаар ХЭХ төслийн удирдагчаар мэдээлэл хийлгэлээ.
- Төслийн бүхий л үйл ажиллагааг хүний эрхийг дээдэлсэн, ялгаварлан гадуурхах байдлын эсрэг, олон нийтийн эрх тэгш оролцоог дэмжсэн зарчмаар зохион байгуулж байна.
- ЭМГ, БСГ-ын мэргэжилтнүүдийн сумын ЭМТ, сургууль, цэцэрлэгүүдэд хяналт үнэлгээг хийхдээ хянах шалгах, буруутай эзнийг олох, хариуцлага тооцох, ажлаас халах зэрэг уламжлалт арга барилыг нь өөрчлөн нөхөрсгөөр зөвлөн туслах, ажил сайжруулах зарчмаар ажиллах арга зүйд сургаснаар анхан шатны нэгж байгууллагын удирдлага болон ажиллагсад ажлаа үнэлүүлэх, дээд шатны байгууллагын зөвлөгөө, дэмжлэгийг авах санал санаачилга гаргах болон дээд байгууллагаа үнэлэх үнэлэмж, сэтгэл ханамж дээшилж байна.

d. Төсөл/Хөтөлбөрт хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах талаар тусгайлан оруулсан эсэх?

- Монгол улсад эрүүл мэндийн болон нийгмийн аливаа үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй, мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 4-5 насаар

бага, мөн эрэгтэйчүүдийн дунд зүрх судас, чихрийн шижин, осол гэмтэл, хоол боловсруулах замын эмгэгүүд эмэгтэйчүүдийнхээс илүүтэй байдаг. Иймд төслийн зүгээс эрэгтэйчүүдийг төслийн үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний мэдлэг хандлагыг өөрчлөхөд тусгайлан анхаарч ажилладаг.

9) Хүрээлэн буй орчин, байгалийн нөөц баялагийг тогтвортойгоор хамгаалах, дэмжихэд төсөл хэрхэн, ямар байдлаар хувь нэмрээ оруулж байна вэ?

Зорилтот аймгуудад Эрүүл орчин аяныг жил бүр аймаг сумдын ЗДТГ, Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж “Эрүүл мэндийг дэмжих Загвар гудамж” хөдөлгөөнийг өрнүүлэн олон нийтийг идэвхижүүлж ажиллаж байна. Энэ ажлын дүнд аймаг бүрт Загвар гудамж бий болж туршлага нь бусад сумдад түгэн дэлгэрч байна. Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж нь гадаад орчны ариун цэвэр тохижилтыг сайжруулах, гадна бие засах газрыг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулах, бохир усны цооног, хог хадгалах сав зэрэг орчныг бохирдуулах зүйлсийг арилгах, стандартын шаардлага хангуулах, ялангуяа сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг байгууллагууд доторхи ариун цэврийн байгууламжтай болох, ашиглалтыг нэмэгдүүлэх зэрэгт анхаарал хандуулан ухуулга нөлөөллийн олон талт ажлуудыг хийж байна.

Уг аяны үр дүнд зорилтот аймгуудад орчны болон гарын ариун цэврийн нөхцлөөс шалтгаалсан халдварт өвчин 30 тохиолдлоор буурсан байна.

10).Зөрчил, хурцадмал байдлыг намжаахад төсөл нь ямар арга замаар дүгнэлт хийн ажилласан бэ ?

Төслийн зүгээс аль болох хамтрагчдыг санал санаачилгыг дэмжиж, хүндэтгэсэн зарчим дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Тухайлбал жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийх үед хамтрагчдын саналыг авч төслийн бодлого зорилттой уялдуулдаг бөгөөд цаг хугацаа, хөрөнгө болон хүний нөөцийн хувьд тэдний боломжийг харгалзан харилцан ярилцах замаар зөрчил маргаан үүсэхээс сэргийлж ажилладаг.

Ялангуяа төрийн байгууллагуудын тухайд төлөвлөлтийн оновчтой бус байдлаас шалтгаалан зарим үйл ажиллагааг жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд хийж амжихгүй байх, санхүүгийн хямралаас шалтгаалан төсөв хасагдсанаас зардал хуваалцах боломжгүй, хүлээгдэх зэрэг эрх ашгийн зөрүүтэй байдал үүсч байсныг тухайн үед харилцан ярилцаж, зөрчил гарахаас сэргийлж, оновчтой хувилбараар шийдэж байлаа.

Жишээ нь: 2015 онд Говь- Алтайн багийн эмч нарын сургалт, Ховд аймагт СӨЭМТ- ийн тайлангийн хурал, Баян-Өлгийд сургуулийн захирлуудын зөвлөлгөөн зэрэг зарим үйл ажиллагаанд харилцан тохиролцож тухайн үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн болно.

Төслийн зөвлөх Биорн Дунд хугацааны үнэлгээний тайлангийн хуралд оролцсон нийт хамтрагчдад Зөрчил түүнийг удирдах талаар лекц бэлтгэн танилцуулсан нь тэдний хувьд чухал бас шинэ мэдээлэл байлаа. Мөн төслийн ажилтнуудад дээрх сэдвийн талаар зөрчлийг үнэлэх хохиролгүйгээр үйлдэх аргын талаар онол дадал хосолсон сургалт зохион байгуулна.

Төслийн ажилтнууд мэдлэгтэй болсноор цаашид зөрчил болон хурцадмал байдлын үнэлгээг тогтмол хийж, үйл ажиллагаандаа мөрдөх болно.

11) Сайн төсөл/ санхүүжилтийн менежментийг дэмжихэд төсөл хэрхэн ажилласан бэ? Өмнөх жилийн аудитийн зөвлөмжийг 2015 онд хэрхэн хэрэгжүүлсэн талаар багтаан бичнэ.

- Өмнөх жил аудитаас баримтын бүрдүүлэлт дээр өгсөн зөвлөмжийн дагуу дэмжих баримтуудыг бүрдүүлэхэд бүх ажилтнууд анхаарч ажиллаж байна.

- Оны эхэнд жилийн зөвлөлдөх уулзалтад оролцсон хамтрагчдад байгууллагын суурин төлөөлөгч Бертил Андерсон Авилга түүний хор уршиг, Авилгаас сэргийлэх талаар тусгайлан сургалт зохион байгуулсан.

- Төслийн ажилтнууд удирдах зөвлөлийн уулзалт болон бусад уулзалтууд дээр хамтрагчдад байгууллагын санхүүгийн дүрэм, тариф, журам зааврыг нээлттэй танилцуулж ажилладаг.

12) DIGNI-ийн зөвлөмж, санал, төслийн урьдчилсан нөхцөл байдлыг бататгах, хэрэгжүүлэхийн тулд юу хийсэн бэ?

Төслийн удирдагч мөн оны 6-р сард Норвеги дахь төв байгууллага дээр ажиллах үед өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайланд тусгасан болно.

Зөвлөмж	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Хүйсийн тэгш байдлын анализыг төслийн үйл ажиллагаанд хийж хэвших	2016 онд төслийн ажилтнуудад тусгайлсан сургалт зохион байгуулна.
Зөрчил маргаанаас сэргийлэх дүн шинжилгээг хийж үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллах	<ul style="list-style-type: none"> - Хамтрагчдад төслийн зөвлөх Биорн Зөрчил маргаан түүнээс хэрхэн сэргийлэх талаар сургалт хийв. - Мөн төслийн ажилтнуудад тусгайлсан сургалт зохион байгуулна. Үйл ажиллагаанд анализ хийнэ.
Дунд хугацааны үнэлгээг оновчтой, үр дүнтэйгээр зохион байгуулах	ДХҮ-г 14 хоногт зохион байгуулсан. Тайлангийн хурал хийгдэж хамтрагчдад үнэлгээний дүнг танилцуулсан. Хамтран ажиллах чиглэл гаргасан. Тайланг Норвеги руу илгээсэн. Үнэлгээний зөвлөмж хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.
Бодит өөрчлөлтийн түүх цуглуулах, төслийн үр дүнг үнэлэхэд төслийн ажилтнууд илүү суралцах	Түүхийг цуглуулах, нэгтгэх, дүгнэх, үйл ажиллагаанд анхаарах талаар төслийн удирдагч ажилтнуудад зөвлөлгөө өгсөн. Ажилтнуудын дотоод сургалтын үед дахин мэдээлэл өгөхөөр бэлтгэж байна.

13) Энэ жилийн хамгийн чухал туршлага/сургамжаа дурдана уу

Турилага:

- Төслийн үйл ажиллагааг үндэсний түвшинд таниулах ухуулга нөлөөлөл сайн хийгдсэн.
- Үндэсний түвшний хамтрагчдын оролцоо дэмжлэг, хамтын ажиллагаа сайн байсан.
- Зорилтот аймгуудад эрүүл мэндийн үйл ажиллагаанд удирдлагуудын оролцоо дэмжлэг сайжирсан, байгууллага хоорондын хамтын ажиллагаа дээшилсэн. Орон нутгийн хөгжлийн сангаас эрүүл мэндийн байгууллагад олгож буй хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн.
- АЭМГ-ийн мэргэжилтнүүдийн бие биенээ орлон гүйцэтгэх, багаар хамтран ажиллах, хяналт үнэлгээ хийх ур чадвар жигд дээшилсэн, хяналт үнэлгээг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө хүсч захиалж хийлгэдэг болсон.
- СӨЭМТ-д дотооддоо хяналт үнэлгээ хийх шалгах хуудсыг хэрэглэж эхэлсэн.
- Эрүүл мэнд, боловсрол, хэвлэл мэдээллийн ажилтнуудын бүсийн зөвлөлдөх уулзалтыг аль нэг аймгийн шилдэг байгууллага дээр зохион байгуулснаар харилцан туршлагаасаа суралцахад илүү үр дүнтэй байв.
- Эмнэлгийн мэргэжилтнүүдийг шавилан сургалтад хамруулан мэдлэг ур чадварыг нь дээшлүүлдэг, сумдад зөвлөн туслах баг ажиллуулдаг зэрэг туршлагуудыг үндэсний хэмжээнд үнэлж, зарим аймгуудад нэвтрүүлж байна.
- Төслөөс анх санаачлан сүүлийн 2 жил зохион байгуулсан “Эрүүл мэндийн олимпиад”-ыг энэ жил улс орон даяар ЕБС-ын сургуулиудын сурагчдын дунд зохион байгуулав.
- Амны хөндийн эрүүл мэнд, эрүүл орчин, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх эрүүл мэндийн аянуудыг аймгууд хамтран зохион байгуулж хэвшсэн бөгөөд “Эрүүл шүдтэй анги”, “Шилдэг үйл ажиллагаатай эрүүл мэндийн кабинет”, ”Эрүүл мэндийг дэмжигч

загвар сургууль”-ууд бий болж бусдадаа туршлагаа түгээж байна. Хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 20 хувиар буурчлаа.

- Эрүүл мэндийн үйл ажиллагаанд боловсролын байгууллагын оролцоо, санхүүжилт нэмэгдэж байна. Тухайлбал: “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье”, “Хүүхдийн осол гэмтээс сэргийлэхэд багш сурган хүмүүжүүлэгч нарын үүрэг, оролцоо” сэдэвт цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлуудын сургалтын 4.723.000 төгрөгийн санхүүжилтын 39,7 хувийг буюу 1.876.000 төгрөг хамтрагчдын оролцоо байлаа.¹⁵

Сурга.мэс:

- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг төслийн үйл ажиллагаанд жигд хамруулах. Учир нь дунд хугацааны үнэлгээний асуумж судалгааны дүнд төслийн үйл ажиллагаа болон байгууллагын талаар мэдэхгүй гэсэн хариулт сурагчдын дунд нэлээд байсан.¹⁶
- Олон нийтийн эрүүл дадал хандлагыг үнэлэх, тэдний хэрэгцээнд суурилсан, зорилтот бүлэгт чиглэсэн сургалтыг зохион байгуулахад анхаарах
- Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудад “Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж” зөвхөн төслийн санаачилга, дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж, хүрээ багатай байгаад анхаарах
- Эрүүл мэндийн сүлжээ байгуулах шалгуур үзүүлэлтийн биелэлт төдийлөн үр дүн багатай, хангалттай бус байсаар байна. Учир нь хэвлэл мэдээллийн байгууллагууд ашгийн төлөө хувийн хэвшлийн нэгжүүд тул нэмэлт санхүүжилт авахгүйгээр сүлжээнд нэгдэх боломжгүй гэдгээ илэрхийлсэн хэвээр байна.
- ЭМГ-ын мэргэжилтнүүд тогтвортой ажиллахгүй, байнга өөрчлөгдөж, шинэчлэгдэж байгаа тул тэднийг дахин сургах хэрэгцээ байнга гарч байна.
- Бүсийн зөвлөлдөх уулзалт нь туршлагыг түгээх, нэг нэгнээсээ суралцах боломжийг олгодог ч хамрах хүрээ цөөн, мэдээллийг бүх СӨЭМТ-үүдэд түгээж чадахгүй байна.
- Сургуулийн эмч нарын зайны сургалтанд хамрагдалт хангалтгүй байна.

14) Digni-ний гишүүн бусад байгууллага, орон нутгийн ТББ-ууд, орон нутгийн засаг захиргаа зэрэгтэй хэрхэн хамтарч ажилласан бэ? Туршлага судласан эсэх?

- Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ, БСГ, ХГБХХ, СӨЭМТ, аймгийн нэгдсэн эмнэлэг, цагдаагийн хэлтэс, сургууль, цэцэрлэгүүд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, ДЗМОУБ, Насан туршийн боловсролын төв, сургуулийн захирлуудын холбоо, эрүүл мэндийг дэмжигч клуб, “Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж”-ны иргэд, эмэгтэйчүүдийн ТББ-тай хамтран Хүүхэд болон Орчны эрүүл мэнд аянууд, сургалт, сурталчилгааг зохион байгууллаа. Аймаг бүрт хамтрагчдын оролцоо, дэмжлэг харилцан адилгүй байдаг.
- УБ төслийн 3 ажилтан Тайвань улсан АХЭМ – ийн чиглэлээр, төслийн удирдагч Норвеги улсад ажиллаж зарим байгууллагуудын туршлага судлан эдгээр туршлагуудыг хамтрагчдад таниулах ухуулга нөлөөллийн ажлууд хийхээс гадна төслийн үйл ажиллагаагаар дамжуулан зорилтот аймгуудад хэрэгжүүлэн ажиллаж байна.

15) Жилийн турш төслийн үйл ажиллагаанууд, шалгуур үзүүлэлтүүд болон үр дүнгүүд хянагдсан/арга хэмжээ авсан тухай тайлбарлаж бичнэ: Төслийн зорилтот бүлгүүдэд, төслийн менежментэд, board/удирдах зөвлөл болон хамтрагч нар

- ЭМТ-үүдийн 100% үйлчлүүлэгчдэд зориулсан хүүхдийн болон амны хөндийн эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээ, осол гэмтлээс сэргийлэх, орчны эрүүл мэндийн тухай сургалт сурталчилгааны гарын авлага материалтай болсон байна.
- ЭМТ-үүдийн 60,9 % нь жилд 1-2 удаа хүүхдийн эрүүл мэнд, эмийн зохистой хэрэглээ сэдвээр 6000 гаруй хүнийг хамруулсан нийгмийн эрүүл мэндийн аян, уралдаан тэмцээн, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

15 Говь-Алтай аймгийн жилийн эцсийн тайлангаас

16 Дунд хугацааны үнэлгээний явц болон тайлангаас

- Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, эмч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийг багш нарыг “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлье”, “Өсвөр үеийнхний эрүүл мэндийн чиг баримжаа олгох” сургагч багшийн сургалт, “Хүүхдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” туршлага судлах уулзалт, арга хэмжээнд бүрэн хамруулж, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон.
- Сургалтанд оролцсон багш, ажилчид цаашдын хийх ажлын төлөвлөгөө боловсруулан сурсан зүйлээ байгууллага, анги хамт олны дунд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган 50 хувь нь БСГ-т хүргүүлэн ажиллаж байна.
- Орчны эрүүл мэнд аяны хүрээнд “Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж” тохижуулах, стандартын шаардлага хангасан бие засах газар, бохир усны цооногийн тоог нэмэгдүүлэх ажлыг аймаг, сумын ЗДТГ, ЭМГ, СЭМТ, ДЗМОУБ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран ажлын хэсэг байгуулан захирамж, тушаал шийдвэр гарган уралдаан болгон дүгнэсэн байна. Орон нутгийн санаачилга, дэмжлэг оролцоо нэмэгдэж байгаа ч харилцан адилгүй байсаар байна.
- Эрүүл орчин бий болгох, хүн амын эрүүл мэндийн талаар насан туршийн боловсрол болон сургуулийн захирлуудын холбоо, эрүүл мэндийн клубууд төсөл бичин, санхүүгийн дэмжлэг авч орчноо тохижуулах, амны хөндийн эрүүл мэндийн сургалт хийж, шүдний үзлэг, сургуулийн захирлуудын сургалт зохион байгуулж ажиллалаа.

16) Энэ жил хяналт үнэлгээг хэрхэн хийсэн талаар бичнэ үү?

- Төслийн үйл ажиллагааны биелэлтийг “Сургалт үйл ажиллагааны төлөвлөгөө”, төслийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг “Хяналт үнэлгээний төлөвлөгөө”-ний дагуу тооцож ажиллалаа. Аймаг бүрийн УЗ-ийн хурлыг 2-3 удаа хийж төслийн үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар хэлэлцлээ.
- 2015 онд хяналт үнэлгээг аймгийн ЭМГ, БСГ, ЭМАШТҮБ-2 төслийн хамтарсан баг хариуцан, БӨ аймагт 9, ГА аймагт 7, Ховд аймагт 10 сумын ЭМТ-д, БӨ, ГА аймаг бүх ӨЭМТ-үүддээ хийсэн байна. Хяналт үнэлгээг эхний хагас жилд 2014 онд боловсруулсан шалгах хуудас, удирдамжийн дагуу, сүүлийн хагас жилд аймаг тус бүрийн боловсруулсан шалгах хуудсын дагуу хийж, дүнг ЭМГ-ын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулан, СЭМТ-үүдэд зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа. Зарим СЭМТ-үүдэд зөвлөмжийн хэрэгжилтийг үнэллээ, Хяналт үнэлгээ хийх үед тухайн сумын эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон олон нийтээс ЭМЯ-наас мөрдөж буй асуумжийн дагуу сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэж, дүгнэлтийг танилцуулсан болно.
- Мөн ЭМГ-ын үйл ажиллагааны талаар эмч мэргэжилтнүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлээ. Зарим сумдад хяналт үнэлгээг төслийн ажилтны оролцоогүй ЭМГ-ын мэргэжилтнүүд хариуцан хийж гүйцэтгэлээ.
- УБ төслийн ажилтнууд болон төслийн удирдагчийн зүгээс орон нутагт ажиллах хугацаанд төслийн ажилтнуудад дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хяналт үнэлгээнд ач холбогдол өгч ажилладаг. ЭМГ-ын мэргэжилтнүүдийн дотоод сургалтаар аймаг бүхэн өөрсдийн хяналт үнэлгээний аргачлалыг боловсруулсан бөгөөд 1-2 суманд хяналт үнэлгээ хийж, ажлын хэсгийн уулзалтаар дахин сайжруулан ажиллаж байна.
- Сургуулийн орчноос хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх дотоод үнэлгээний аргачлалыг Ховд аймгийн 7 дугаар сургууль тогтмол үнэлж хэвшсэнээс гадна үнэлгээний 5 модулиар эрүүл мэндийн кабинетаа тохижуулан эцэг эх, сурагчид, багш ажилтнуудад сурталчилан кабенитыг ашиглах хуваарь гаргаж, өөрсдөө үйл ажиллагаагаа хянах аргачлалд суралцаж байна.
- Шалгуур үзүүлэлт бүрийн биелэлт, бодит өөрчлөлтийн түүх, эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн статистик мэдээлэл зэргийг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж, дүгнэлт хийн ажиллаж байна. Мөн дунд хугацааны үнэлгээнд шаардлагатай тоо баримт, тайлбарыг бэлтгэн үнэлээчид хүргүүлж ажиллав.

17) Сүүлийн жилд төсөлд үнэлгээ хийгдсэн үү?

а/ 2015 оны үнэлгээ: Төслийг сайжруулах болон суралцахад энэхүү үнэлгээ нь ямар байдлаар хувь нэмэр оруулсан вэ?

ЭМЯ- тай хамтран Ховд аймгийн Чандмана, БӨ аймгийн Улаанхус сумын Сувилахуйн загвар ЭМТ- үүдэд үнэлгээ хийлгэн өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Мөн Эрүүл мэндийн загвар 6 төвийг аймгуудын ЭМГ-тай хамтран боловсруулсан шалгуураар үнэлэн батлавжлав.

2015 онд төслийн дунд хугацааны үнэлгээ хийгдсэн. Тухайн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, үйл ажиллагааг доорх хүснэгтэд тусгасан болно.

Дүгнэлт
- ЭМАШТҮ-г дэмжих орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааны бүтэц бий болсон байна.
- Бүх түвшинд ЭМЯ, БЯ болон орон нутгийн удирдлагын дэмжлэг авч чадсан.
- Үйл ажиллагаа бүрийн дараа хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцдог болсон байна
- Төслийн аймгуудын хүн ам ихэнх нь өвдсөн үедээ СӨЭМТ-үүдэд очиж үйлчлүүлж байгаа нь АШТҮний чанар, хүртээмж дээшилсэнийг илтгэж байна.
- Олон нийтийн СӨЭМТ-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамж сайн байгаа нь АШЭМ тусламж үйлчилгээ хангалттай байна.
- Эрүүл мэндийн үзүүлэлтүүдэд эерэг сайн өөрчлөлт гарсан.
- Амны хөндийн эрүүл мэнд, гар угаах, эрүүл орчин бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжигч загвар гудамж, эрүүл мэндийн загвар төвүүдийн үйл ажиллагаа зэрэг төслийн гол анхаарал хандуулсан үйл ажиллагаануудад харагдахуйц үр дүн өгсөн байна.
- Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд шүд болон гар угаах дадлыг дэмжих орчин сайжирсан байна.
- Иргэдийн түлэгдлийн талаарх мэдээлэл бага, эмийн зохистой хэрэглээ хангалтгүй байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай эрүүл мэндийн сүлжээ байгуулах зорилт хангалтгүй байна.
- Тодорхой чиглэлээр бүсийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулдаг нь маш үр дүнтэй байна.
- Эрүүл мэндийг дэмжигч загвар гудамжны үйл ажиллагаанд шат шатны ЗДТГ-ууд, багийн дарга нар идэвхтэй оролцож, урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зэрэг нааштай өөрчлөлтүүд гарсан байна.
- Эрүүл мэндийг дэмжих хамт олон, үе тэнгийн сургагч багшийн сургалт, эрүүл мэндийн аян, уралдаан тэмцээн зохион байгуулсан нь илүү үр дүнтэй байна.
Зөвлөмж
- Одоогийн хүрсэн түвшин, ололт амжилтыг тогтворжуулан төслийг үргэлжлүүлэх
- ЗДТГ, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаанд цаашид илүүтэй анхаарал хандуулах
- Түлэгдэл, осол гэмтлээс сэргийлэх мэдээллийг сурагчдад сонирхолтой арга хэлбэрээр, иргэдэд өрх, сумын эрүүл мэндийн төв, гар утас, интернет ашиглан хүргэх үйл ажиллагааг төслийн үлдсэн хугацаанд үргэлжлүүлэх
- Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд тусгайлан стратеги боловсруулан хэрэгжүүлэх
- Загвар төвүүдийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох арга хэмжээ, бүсийн уулзалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулах
- Эмийн зохистой хэрэглээ, хүүхдийн хараа хамгаалал, хүүхдийн нас баралтыг бууруулахад тусгайлан төсөл хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх.
Үйл ажиллагаа

- ДХҮ-ний тайлангийн хуралд үндэсний болон орон нутгийн хамтрагчдыг оролцуулан цаашид төслийн тогтвортой байдлыг хэрхэн хангах, хүрсэн үр дүн ололтыг бэхжүүлэх, хамтран ажиллах талаар зөвлөмж гаргав.
- Үнэлгээний дараа аймгуудад СӨЭМТ-ийн жилийн тайлангийн хурал хийж, ДХҮ ний дүгнэлт, зөвлөмжийг танилцуулан аймаг бүр цаашид анхаарах асуудлаа тодорхойллоо.
- БӨ аймагт сургуулийн захирлуудын холбоотой хамтран “Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд сургуулийн удирдлагын оролцоо” сэдэвт сургалт, зөвлөлгөөн хийж мөн ДХҮ-ний зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэрхэн хамтран ажиллах талаар нэгдсэн ойлголтод хүрлээ.
- Аймгуудын удирдах зөвлөлийн хуралд ДХҮ-ний тайлан дүгнэлтийг хэлэлцүүлэн аймаг бүр зөвлөмж хэрэгжүүлэх ажлын чиглэлээ гаргалаа.
- Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх болон эмнэлгийн мэргэжилтний сургалт, Загвар төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах болон хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр ЭМЯ, БСШУЯ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна.
- 2016 оны нэгдүгээр сард төслийн ажилтнуудын дотоод сургалтыг зохион байгуулж үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар дахин хэлэлцэж, тухайн оны төлөвлөгөөнд нарийвчлан тусгахаар төлөвлөж байна.

18) Бусад нэмэлт:

Түүх №1

Он сар өдөр: 2015.09.17.

Түүх цуглуулсан газар: ГА аймгийн Есөнбулаг сум ЭМГ

Хаяг: ГА аймаг, Есөнбулаг сум, ЭМГ

Утасны дугаар : 99483839

Түүхийн нэр: “Хяналтын хуудас боловсруулсан нь”

1. Төслөөс ЭМГ-ын мэргэжилтнүүдийг чадваржуулах сургалтуудыг үе шаттай зохион байгуулдаг ба түүнд оролцсноор мэдлэг чадвараа тасралтгүй дээшлүүлдэг болсон. “Судалгаа хийх арга зүй” сургалтанд хамрагдсны дараа “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр хөтлөлт, жирэмсэн эхийн хөтчийн хөтлөлт, ашиглалтыг үнэлэх хяналтын хуудсыг боловсруулсан. Тус хяналтын хуудсаар сум өрхийн ЭМТ-үүд болон эцэг эх, асран хамгаалагчид эх, хүүхдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээлэл, хяналт ямар түвшинд байгааг үнэлсэн.

ЭХЭМД-ийн хөтлөлт СӨЭМТ-үүдэд жигд сайн биш, тус дэвтрийн ач холбогдлын талаар эмч мэргэжилтнүүд эцэг эхчүүдэд мэдлэг хангалтгүй байсан. Тус хяналтын хуудас нь ашиглахад хялбар хэн ч үнэлгээг хийх боломжтой тул СӨЭМТ-үүдэд ажиллах үедээ үнэлгээг хийдэг болсон.

2. ЭХЭМД, жирэмсэн эхийн хөтчийн зөв хөтлөн, ашиглалтыг сайжруулбал эцэг эхчүүдийн хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл мэндийн талаарх мэдлэг сайжирч, хяналт нэмэгдэн, хүүхдийн өвчлөл эндэгдэл буурахад эерэг нөлөөтэй юм. Тиймээс энэ үнэлгээний дараа эмч мэргэжилтнүүд болон эцэг эхчүүдэд зориулсан сургалт, зөвлөлгөөг СӨЭМТ-үүдтэйгээ хамтран зохион байгуулсан.

Энэхүү хяналтын хуудсуудаар үнэлгээг тогтмол хийснээр СӨЭМТ-үүдийн эмч мэргэжилтэн болон эцэг эхчүүдийн ЭХЭМД, жирэмсний хөтчийн хөтлөлт ашиглалт эрс

сайжирсан ба хүүхдийн эндэгдэл тус аймагт сүүлийн 3 жил дараалан буурсан дүнтэй байна. /2013 онд 30,3, 2014 онд 26,9, 2015 онд 15,5/

3. Тус сургалтаас хяналтын хуудас хэрхэн боловсруулах болон түүний ач холбогдлын талаар суралцсан нь тус өөрчлөлтийг бий болгосон ба хүүхдийн эрүүл мэндийн хяналтанд эмч мэргэжилтнүүдүүдээс гадна эцэг эхчүүдийн хяналт нэмэгдэж, тусламж үйлчилгээг цаг алдалгүй авч чаддаг болсон нь хүүхдийн эндэгдэл буурахад эерэг нөлөө үзүүлсэн.

Түүх өгүүлэгч: ГА ЭМГ Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Ш.Майнбаяр

Түүх №2

Он сар өдөр: 2015.12.25

Түүх цуглуулсан газар: БӨ аймгийн Өлгий сум

Түүх өгүүлэгчийн нэр: Сунхар

Хаяг: БӨ аймаг, Өлгий сум, ЭМГ

Утасны дугаар : **99425022**

Түүхийн нэр: “Сувилахуйн тусламж үйлчилгээ сайжирч байна”

1. ЭМАШТҮБ-2 төсөл нь сувилагч нарыг чадваржуулах танхимын сургалт, дадлагажуулах шавилан сургалтыг жил бүр, сувилахуйн загвар үйлчилгээтэй ЭМТ бий болгон, түүний туршлагыг түгээн дэлгэрүүлэх бүсийн зөвлөлдөх уулзалт, аймгийн туршлага судлах уулзалт зэргийг зохион байгуулснаар СЭМТ-д ажиллаж байгаа сувилагч нарын мэдлэг чадвар дээшилсэн. Сувилахуйн загвар Улаанхус суманд 2014 онд сувилахуйн бүсийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах үед манай аймгийн зарим ЭМТ-ийн сувилагч нар ирж оролцон тэдний туршлагаас суралцсан. 2015 онд СЭМТ-үүд өөрсдийн санаачилгаар тус сумын ЭМТ-ийн сувилахуйн тусламж үйлчилгээний туршлагаас судалсан. Эдгээр үйл ажиллагааны дараа сумын ЭМТ-үүд хүнд өвчтөний хооллох ширээ, ханын бариул, дэр өндөрлөгч, дасгал хийх дугуй, цэвэрлэгээний тэргэнцэр, дамнуурга зэргийг гарын дорх материал ашиглан хийсэн. СӨЭМТ-ийн 40% нь сувилахуйн тусламжийн багцуудыг шинээр хийснээр өвчтнүүдэд сувилгаа үзүүлэх материаллаг хэрэгцээгээ хангасан байна.
2. Сургалт үйл ажиллагаанаас өмнө сувилагч нар сувилагаа үзүүлэх багаж тоног төхөөрөмж байхгүй гэдэг шалтгаанаар сувилгаа хийдэггүй, зөвхөн эмчийн бичсэн эмчилгээг хийх байдлаар сувилахуйн тусламж үзүүлдэг байсан. Эдгээр сургалт, туршлага судлах уулзалтаас өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан сувилгааны иж бүрдэл, зарим багаж хэрэгслүүдийг хийх аргыг суралцсан. Багаж хэрэгсэлтэй болсноор үйлчлүүлэгчдэд нэн шаардлагатай сувилгааны тусламжийг үзүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж байна.
3. Ижил нөхцөлд ажиллаж байгаа сувилагч нарынхаа хэрэгжүүлж үр дүнд хүрсэн туршлагыг өөрийн биеэр үзэж танилцан, арга зүйг нь суралцсан нь энэхүү өөрчлөлтийг гаргахад нөлөөлсөн.

Түүх бичсэн: Д.Күнай /БӨ Төслийн ажилтан/

Түүх №3

Он сар өдөр: 2015.12.23

Түүх цуглуулсан газар: Ховд аймгийн Жаргалант сум

Түүх өгүүлэгчийн нэр: 7-р сургуулийн эрүүл мэндийн багш Мөнгөнтөгтох:

Хаяг: Ховд аймгийн Жаргалант сум 12 жилийн 7-р сургууль

Утасны дугаар :

Түүхийн нэр: “Эрүүл мэндийн өргөө”

АБСГ, төслөөс хамтран “Эрүүл мэндийн кабинет” шалгаруулах уралдаан зарласан. Тус уралдааны болзлын дагуу манай сургуулийн удирдлага, багш нар хамтран “Амны хөндийн эрүүл мэндийн өргөө”-г бий болгосон. Тус өргөөнд шүдний хэлбэртэй сандал, хэлний хэлбэртэй ширээ хийж, тайзыг нь хоншоор хэлбэртэй болгон зассан. Мөн гарын дорх материал ашиглан сургалтын иж бүрдлүүдийг хийсэн. Мөн төслөөс боловсруулан гаргасан “Сургуулийн орчноос хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлийг үнэлэх” дотоод үнэлгээний аргачлалыг хэрэгжүүлж, тухайн өргөөг тус үнэлгээний 5 модулиар 5 хэсэг болгон тохижуулсан. Өргөөтэй болсноор эрүүл мэндийн хичээлийг бодит үзүүлэнг ашиглан, дадлага хийлгэх хэлбэрээр явуулах боломжтой болсон. Ингэснээр хүүхдүүд эрүүл мэндийн хичээлд сонирхолтой болсон. Мөн тус өргөөнд тодорхой хуваарийн дагуу багш ажилчид, сурагчид, эцэг эхчүүд хөдөлгөөнт дасгалыг хийж, эрүүл мэндийн мэдээлэл авдаг. Үүний үр дүнд эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа сайжирч байна. Эрүүл мэндийн өргөөтэй болсноор эрүүл мэндийн клубын хүүхдүүд үйл ажиллагаагаа тогтмол, явуулж чаддаг болсон.

Эрүүл мэндийн кабинеттэй болж, үйл ажиллагаа нь тогтмолжсоноор:

- Багш ажилчдад эрүүл мэндийн мэдлэг олгох үйл ажиллагаа тасралтгүй явуулах боломж бүрдсэн.
- Бүх багш нар сурагчдынхаа эрүүл мэндэд анхаардаг болж, эцэг эхчүүдийн оролцоо ч нэмэгдсэн.
- Эрүүл мэндийн чиглэлээр маш олон ажлуудыг санаачилан зохион байгуулдаг болсон.

Сургуулийн орчноос хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх аргачлалыг тогтмол хэрэглэснээр хүүхдүүдийг эрүүл аюулгүй орчин бий болгох талаар сурагчид, эцэг эхчүүд, багш, ажилчид, удирдлагууд жигд мэдээлэлтэй болж, бүх хүмүүсийн оролцоо нэмэгдсэн.

Энэхүү өөрчлөлтийг бий болгоход тус уралдаан үндэс нь болсон бөгөөд сургуулийн удирдлагын дэмжлэг сайн, багш ажилчид маань нэг баг болон ажилладаг, сэтгэлээсээ ажилладаг зэрэг нь нөлөөлсөн.

Түүх бичсэн: Ж.Лусалмаа-ЭМАШТҮБ-2 төслийн ажилтан

Тайлан бичсэн: Төслийн ажилтнууд

Хянасан: Давид Олсон /Суурин төлөөлөгч/
Биорн Сорхус /Төслийн зөвлөх/
Клаудиа Осориа /Төслийн зөвлөх/

Эцэслэсэн: С.Баяржаргал /Төслийн удирдагч/

